



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН  
ГИШҮҮНИЙ ТОГТООЛ

Улаанбаатар хот

2021 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 43

Үндсэн хуулийн цэцийн гишүүн Б.Буяндэлгэрийн  
саналын тухай

Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Солонго нэр бүхий иргэдээс ирүүлсэн мэдээллийг урьдчилан шалгаад 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдөр "Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх тухай" 11 дүгээр тогтоол, 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдөр "Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх тухай" 12 дугаар тогтоол, мөн өдрийн "Маргаан нэгтгэн шалгах тухай" 13 дугаар тогтоол, 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр "Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг нэгтгэн шалгах тухай" 16 дугаар тогтоолыг тус тус гаргасан байна.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн Б.Буяндэлгэр маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх болон нэгтгэн шалгах тухай дээрх тогтоолыг эс зөвшөөрч 2021 оны 3 дугаар сарын 09-ний өдөр гаргасан саналыг хуульд заасан маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны журмын дагуу шинээр эхэлж явуулахад дараах нөхцөл тогтоогдсоныг

**ХЯНАВАЛ:**

1. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн гишүүн иргэдээс ирсэн өргөдөл, мэдээллийг урьдчилан шалгаж, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзах тухай шийдвэрт гомдол гаргасан нөхцөлд Цэцийн бага суудлын хуралдаанаар хэлэлцэхээр зохицуулсан байна.

Цэцийн аль нэг гишүүн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэх талаарх Цэцийн гишүүний шийдвэрийг эс зөвшөөрч санал гаргах эрхтэй боловч уг саналыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу "3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаан"-аар хэлэлцэхээр байна. Харин ийм санал гаргах эрх зүйн үндэслэл, журам мөн түүнийг хэрхэн хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх эрх зүйн зохицуулалтгүй байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт "Цэцийн гишүүн ... өөрийн санал, дүгнэлтийг ... ямар нэгэн хэлбэрээр урьдчилан илэрхийлэхийг хориглоно." гэж, түүнчлэн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт

1774876

"Цэцийн гишүүн хянан шалгаж байгаа маргааны талаархи саналаа урьдчилан хэлэх, энэ талаар бусдад зөвлөгөө өгөх эрхгүй." гэж заасан.

Гэтэл Үндсэн хуулийн цэцийн гишүүний гаргасан саналд "...Цэц 1997 оны дүгнэлтийг гаргахдаа Үндсэн хуульд заасан иргэний сонгох, сонгогдох үндсэн эрхийг дордуулахгүйн үүднээс П.Очирбатыг гурав дахь удаагаа Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллах боломж олгож, нэр дэвшигчээр бүртгэн авсан.", түүнчлэн "...Цэцийн гишүүн иргэнээс гаргасан өргөдөл, мэдээллийг урьдчилан шалгаж, хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзаж тогтоол гаргахаар зохицуулсан байтал маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсэн байна." гэж өөрийн санал дүгнэлтийг урьдчилан илэрхийлсэн байна. Үндсэн хуулийн цэцийн гишүүний иш татсан Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаар дүгнэлтэд дээрх утга, агуулга бүхий үндэслэл дурдагдаагүй байна.

3. Үндсэн хуулийн цэцийн гишүүн гаргасан саналдаа Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн холбогдох хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх талаарх үндсэн маргааны агуулгыг хөндсөн бөгөөд маргааны шинжид хамааралгүй, Цэцэд мэдээлэл гаргасан иргэдтэй холбоотой хувийн дүгнэлтээ дурдсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн агуулга болон зарчимд нийцэхгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 2 дугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн заалтыг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

1. Үндсэн хуулийн цэцийн гишүүн Б.Буяндэлгэрийн 2021 оны 3 дугаар сарын 09-ний өдөр гаргасан саналыг Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаар хэлэлцүүлэх үндэслэлгүй гэж үзсүгэй.

ГИШҮҮН



Ж.ЭРДЭНЭБУЛГАН